



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/123

Зуунмод сум

Зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зохицуулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагнал журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/160 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Жуух, Хүндэт тэмдэг хийлгэхэд зарцуулагдах зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Шагналд зарцуулагдах 28,340,000 (хорин найман сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Магнайбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МОНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
03-р сарын 03-ны өдрийн А/123-р
захирамжийн 4-р хавсралт



ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хүндэт тэмдэг (хайрцагтай)	1,000	18,000	18,000,000
2	Хүндэт тэмдэг (Үнэмлэх, хавтас)	1,000	2,090	2,090,000
3	Жуух	1,000	8,250	8,250,000
НИЙТ ДҮН				28,340,000

ТӨСӨВ ХИЙСЭН:
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА  Э.БАЯРБАТ

ТӨСӨВ ХЯНАСАН:
СТСХ-ИЙН ТӨСВИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  Ч.ЦЭЦЭГСҮРЭН